

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн бие даасан хараат бус байдлыг хангах, олон ургальч, чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд оршино.

##### 2 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Харилцаа холбооны тухай хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль болон энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр олон нийтийн эрх, ашиг сонирхолын төлөө мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан хараат бус, ил тодоор хэвлэн нийтлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

3.2.Бие даан сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн бүтээл, түүнтэй холбоотой харилцаа нь энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

##### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“сэтгүүл зүйн үйл ажиллагаа” гэж олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор мэдээ мэдээлэл хайх, хүлээн авах, цуглуулах, боловсруулах, нягтлах үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр түүнийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтлэх, нэвтрүүлэх, түгээх мэргэжлийн үйл ажиллагааг;

4.1.2.“сэтгүүлч” гэж мэдээ, мэдээлэл хайх, эрэн сурвалжлах, цуглуулах, боловсруулах, нягтлах, агуулга бүтээх, түгээхтэй холбоотой сэтгүүл зүйн үйл ажиллагааг

тодорхой хэвлэл мэдээллийн байгууллагын редакцид хамааран орон тооны болон орон тооны бус байдлаар эсхүл бие даан чөлөөт байдлаар гүйцэтгэж байгаа хүнийг;

4.1.3.“хэвлэл мэдээллийн байгууллага” гэж редакцаар дамжуулан сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг, сонин, сэтгүүл, радио, телевиз, редакцтай цахим хуудас /вэб сайт/ хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшдэг хуулийн этгээдийг;

4.1.4.“хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэж сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллийг олон нийтэд, эсхүл тодорхой бүлэг этгээдэд хүргэх, түгээх зорилгоор ашиглаж байгаа сонин, сэтгүүл, радио, телевиз, редакцтай мэдээллийн цахим хуудсыг /вэб сайт/;

4.1.5.“хэвлэл мэдээллийн байгууллагын редакц” гэж хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтэд түгээх мэдээллийн агуулга, бодлогыг тодорхойлох, бүтээх, нягтлах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа нэгж, хүнийг;

4.1.6.“хүйн хэвлэл мэдээллийн байгууллага” гэж соёл, зан заншил, үнэт зүйл, сонирхол, онцлог байдлаар нэгдсэн иргэдээс үүсгэн байгуулж, эзэмшиж, удирдаж байгаа, хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, мэдээ, мэдээллийг иргэдийн оролцоонд тулгуурлан боловсруулж, түгээх зорилготой, ашгийн бус, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшдэг хуулийн этгээдийг;

4.1.7.“эх сурвалж” гэж сэтгүүлчийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээллийн үндэслэл болж байгаа үйл баримт, мэдээллийг өгч байгаа этгээдийг;

4.1.8.“эх сурвалж нууцлах эрх” гэж хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлч нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалж, мэдээллийг дамжуулсан арга хэрэгслийг гуравдагч этгээдэд илчлэхгүй байхыг;

4.1.9.“худал мэдээлэл” гэж бусдын сэтгэл санаа, бие махбодь, эсхүл бизнесийн үйл ажиллагаанд хохирол учруулах зорилгогүйгээр түгээсэн бодит байдалд нийцэхгүй гэдгийг мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан энэ хуулийн 4.1.10-т зааснаас бусад алдаатай мэдээллийг;

4.1.10.“илт худал мэдээлэл” гэж бодит үйл явдалд тулгуурласан боловч тухайн үйл явдлыг хэт дэвэргэх, буруу ойлголт төрүүлэхээр зориуд дутуу мэдээллэх эсхүл бодит үйл явдал болсон мэтээр зохиож ор үндэслэлгүй худал мэдээлэл, баримт сэлтийг хувь хүн, хуулийн этгээд, байгууллага, улс оронд санаатайгаар хохирол учруулах зорилгоор түгээсэн мэдээллийг.

## **5 дугаар зүйл.Сэтгүүл зүйн үйл ажиллагаанд баримтлах зарчим**

5.1.Сэтгүүл зүйн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

10.1.1.хараат бус, бие даасан байдлаар тэнцвэртэй мэдээллэх;

10.1.2.хүнлэг, шударга ёсыг баримтлах;

10.1.3.олон нийтийн эрх ашгийг урьтал болгож хувийн ашиг сонирхол, сэтгэл хөдлөлийг тэвчих;

5.1.4.итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэхдээ баримтад тулгуурлах.

5.2.Хэвлэл мэдээллийн байгууллага нь бодит мэдээлэл, баримтад тулгуурласан мэдээллийг түгээх бөгөөд энэ хуулийн 5.3-т зааснаас бусад тохиолдолд өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

5.3.Ил мэдээлсэн эх сурвалжийн мэдээлэл, үзэл бодлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулсан, нийтэлсэн, нэвтрүүлсэн бол энэхүү мэдээллээс үүсэх хариуцлагыг тухайн ил мэдээлсэн эх сурвалж хариуцна.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙДЛЫН БАТАЛГАА**

### **6 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс хангах баталгаа**

6.1.Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль, захиргааны хэм хэмжээний акт батлахыг хориглоно.

6.2.Хэвлэн нийтлэх эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулсны төлөө сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг төрөөс аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх, хэвлэн нийтлэх бүтээлд агуулгын хяналт тогтоохыг хориглоно.

6.3.Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд агуулгын хяналт тавих байгууллага, албан тушаал бий болгохгүй бөгөөд ийм үйл ажиллагааг санхүүжүүлэхийг хориглоно.

6.4.Төрийн байгууллага нь гамшиг, аюулт үзэгдлээс бусад үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхээр шаардахыг хориглоно.

6.5.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагааг тусгайлан сурталчлуулах бол хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулна. Энэ талаарх үйл ажиллагааг ил тод, нээлттэй мэдээлнэ.

6.6.Энэ хуулийн 6.6-д заасан этгээдийн хэвлэл мэдээллийн үйлчилгээ авахад холбогдох төсөв хуваарилах, зарцуулах журмыг Засгийн газар баталж, мөрдүүлнэ.

6.7.Монгол Улсын тухай албан ёсны мэдээллийг олон улсад түгээх, сурталчлах зорилго бүхий хэвлэл мэдээллийн байгууллага байна. Энэ хэсэгт заасан хэвлэл мэдээллийн байгууллага нь арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй бөгөөд улсын хэмжээнд нэг байж Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд үйл ажиллагаагаа явуулна.

6.8.Энэ хуулийн 6.7-д зааснаас бусад зорилгоор төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь дэргэдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажиллуулахыг хориглоно.

6.9.Төрийн байгууллага, албан тушаалтан нь хэвлэл мэдээллийн байгууллагыг үйл ажиллагаагаа бие даасан, хараат бусаар эрхлэхэд саад учруулах, үйл ажиллагааг нь хуульд зааснаас бусад үндэслэлээр албадан зогсоох, татан буулгах, энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардахыг хориглоно.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “агуулгын хяналт” /цензур/ гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, нэвтрүүлэх мэдээллийн агуулгыг урьдчилж хянах, хөндлөнгөөс нөлөөлөх аливаа үйл ажиллагааг ойлгоно.

## **7 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах эрх**

7.1.Монгол Улсын иргэн бүр үндэс, угсаа, хэл, соёл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн чиг баримжаа, ял шийтгүүлсэн байдлыг үл харгалзан үзэл бодлоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр чөлөөтэй илэрхийлэх, хуульд заасан журмын дагуу хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах, эрхлэх эрхтэй.

7.2.Хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах, бүртгэхтэй холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

## **8 дугаар зүйл.Редакцын хараат бус байдлын баталгаа**

8.1.Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага нь сэтгүүл зүйн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хараат бусаар, чөлөөтэй эрхэлнэ.

8.2.Хэвлэл мэдээллийн байгууллага нь олон нийтэд түгээх мэдээллийн агуулга, бодлогыг тодорхойлох, бүтээх, нягтлах үйл ажиллагааг зохион байгуулах редакцтай байна.

8.3.Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц нь төр, өмчлөгч, ивээн тэтгэгч, улс төрийн байгууллагын хөндлөнгийн оролцоогүйгээр сэтгүүл зүйн үйл ажиллагааг бие даан явуулна. Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, хувь хүн редакцын үйл ажиллагаа, нийтлэлийн бодлогод хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

8.4.Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц нийтэлж, нэвтрүүлж буй бүтээлийн агуулгын бодит байдлыг хариуцна.

8.5.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн нийтэд түгээсэн мэдээллийг энэ хуулийн 4.1.9, 4.1.10-т заасан мэдээлэл байсан гэж үзвэл эрх нь хөндөгдсөн этгээд гомдлоо редакц, энэ хуулийн 13.1-д заасан хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагад гаргаж болно.

8.6.Хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигч нь редакцын хараат бус байдлыг хангах, талуудын эрх, үүргийг тодорхойлох гэрээ байгуулна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ**

### **9 дүгээр зүйл.Хэвлэл мэдээллийн байгууллага**

8.1.Хэвлэл мэдээллийн байгууллага нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус зорилготой, олон нийтийн, хүйн, арилжааны төрөлтэй байна.

8.2.Олон нийтийн болон хүйн хэвлэл мэдээллийн байгууллага нь ашгийн төлөө бус зорилготой байна.

8.3.Энэ хуулийн 8.2-т зааснаас бусад хэвлэл мэдээллийн байгууллага нь ашгийн төлөө зорилготой, компани хэлбэрээр зохион байгуулагдсан байна.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасан олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой харилцааг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зохицуулна.

## **9 дүгээр зүйл.Хүйн хэвлэл мэдээллийн байгууллага**

9.1.Олон ургальч байдлыг дэмжих, иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах зорилгоор тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд, хязгаарлагдмал байдлаар үйл ажиллагаа явуулдаг, соёл, зан заншил, сонирхол, үнэт зүйл, онцлог байдлаар нэгдсэн иргэдийн үүсгэн байгуулж, эзэмшдэг хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажиллаж болно.

9.2.Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хязгаарлагдмал хүрээнд мэдээ, мэдээлэл түгээж, энэ хуулийн 9.1-т заасан иргэдийн оролцоонд тулгуурлан үйл ажиллагаагаа хараат бусаар явуулна.

## **10 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшлийн ил тод байдлыг хангах**

10.1.Хэвлэл мэдээллийн байгууллага нь эзэмшлийн талаарх дараах мэдээллийг олон нийтэд ил тод зарлана:

10.1.1.хуулийн этгээдийн нэр, таван хувиас дээш хувийн хувьцаа эзэмшигчийн нэр, иргэншил, эзэмшиж байгаа хувьцааны тоо;

10.1.2.хэвлэл мэдээллийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;

10.1.3.энэ хуулийн 8.5-д заасан гэрээ.

10.2.Хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр мэдээллийг шинэчилнэ.

10.3.Энэ хуулийн 10.1.1-т заасан этгээд нь хэвлэл мэдээллийн байгууллага дахь хувь эзэмшлээ нуун дарагдуулах, бусдын нэрийг ашиглан улсын бүртгэлд хуурамчаар бүртгүүлэхийг хориглоно.

## **11 дүгээр зүйл.Хэвлэл мэдээллийн хэт төвлөрлөөс сэргийлэх**

11.1.Хэвлэл мэдээллийн салбарт хэт төвлөрөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөөн, олон ургальч үзлийг дэмжих зорилгоор хүн, хуулийн этгээд хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмших байдлыг хязгаарлаж болно.

11.2.Хэвлэл мэдээллийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх, хязгаарлалт тогтоох, үнэлгээ дүгнэлт гаргах, бүртгэхтэй холбогдсон харилцааг Өрсөлдөөний тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулна.

11.3.Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний өмчлөгч нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг алдагдуулсан, редакцын хараат бус байдалд халдсан, хэвлэл мэдээллийн салбарт өрсөлдөөнийг хязгаарласан аливаа үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖАА НУУЦЛАХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ**

### **12 дугаар зүйл.Мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх**

12.1.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй.

12.2.Тухайн мэдээллийн нууцалсан эх сурвалжийг өөр арга замаар олж мэдэх

боломжгүй бөгөөд үндэсний аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой, бодит хохирол учруулахуйц гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэслэлтэй нь шүүхээр тогтоогдсон нөхцөлд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эх сурвалжаа нууцлах эрхийг тус шүүхийн шийдвэрээр хязгаарлаж болно.

12.3.Төрийн байгууллага, албан тушаалтан, бусад этгээд сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад учруулах, энэ хуулийн 12.2-т зааснаас бусад үндэслэлээр мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг албадах, тулган шаардахыг хориглоно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАРЫН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **13 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалт**

13.1.Хэвлэл мэдээллийн салбарт өөрийн зохицуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх байгууллага ажиллана. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага нь бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг бие даан шийдвэрлэнэ.

13.2.Энэ хуулийн 13.1-т заасан байгууллага нь хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг батална.

13.3.Энэ хуулийн 13.1-д заасан байгууллага нь редакцын сэтгүүл зүйн бүтээл нь энэ хуулийн 13.2-т заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн талаарх хүн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг хүлээн авч, хянан хэлэлцэнэ.

13.4.Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага энэ хуулийн 13.3-т заасан үйл ажиллагааны хүрээнд хамтын зарчмаар мэргэжлийн дүгнэлтийг гаргаж, шийдвэрээ нээлттэй мэдээлнэ.

13.5.Энэ хуулийн 15.3-т заасан үйл ажиллагаа нь хүн, хуулийн этгээдийн редакц болон шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **17 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

17.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай болон Захиргааны ерөнхий хуульд заасан, энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

### **18 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

18.1.Энэ хуулийг.....оны.....дугаар сарын...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“14 дүгээр зүйл.Албаны нууцад хамаарах мэдээлэл**

14.1.Албаны нууцад дараах шаардлагыг хангасан мэдээллийг хамааруулна:

14.1.1.үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн байх;

14.1.2.бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахааргүй болох нь тагнуулын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байх;

14.1.3.иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрх, эрх чөлөөг хязгаарлахааргүй байх

14.2.Төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хуулийн этгээдийн хууль бус үйлдлийг нуух зорилгоор мэдээллийг албаны нууцад хамааруулахыг хориглоно.

14.3.Тухайн байгууллага албаны нууцад хамаарах мэдээллийг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Тагнуулын байгууллагын дарга батална.

14.4.Тухайн байгууллага нь албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд багтаан дүн шинжилгээг хийж,тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

14.5.Хүн, хуулийн этгээдэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хязгаарлалттай мэдээллийг өгөхөөс татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тухайн байгууллага тайлбарлах үүрэгтэй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 14.16 дугаар зүйл нэмсүгэй:

**1/14.16 дугаар зүйл:**

“14.16 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль зөрчих

1.Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцын мэргэжлийн үйл ажиллагаа, шийдвэрт хөндлөнгөөс оролцсон, хараат бус байдлыг алдагдуулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Шүүхийн шийдвэр гараагүй байхад сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “тусгаагүй;” гэснийг “тусгаагүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.9 – 32.11 дэх хэсгийн дугаарыг “32.3 - 32.5” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 - 32.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 1998 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА,  
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсгийн “Засгийн газрын бодлого, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт болон цаг” гэснийг “Цаг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл. 2024.11 сар

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.8 дахь заалтын “14.7,” гэсний дараа “14.16,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг